



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2018 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын 2018 оны эхний хагас жилийн тайланд үндэслэн хөрөнгийн тооллого хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга.
Гишүүд:	-Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга;
	-Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга;
	-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын нисэх буудлын асуудал хариуцсан мэргэжилтэн;
	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
Нарийн бичгийн дарга	-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн.

2. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын хөрөнгийн дахин үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэж, хөрөнгийн тооллого болон дахин үнэлгээ хийсэн талаарх тайланг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Ням-Осор/-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ